



## **ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

#### **1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага**

Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын болон олон улсын бусад ажиллагаанд оролцох төрлийг нэмэгдүүлэх, энхийг дэмжих ажиллагааны удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 35-д “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг боловсруулах, Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалтад “хуульд заасны дагуу алба хаагчийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах ажлыг зохион байгуулах” гэж тус тус заасан.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ын 14.4-т “Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд болон олон улсын санхүү, худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхтэй үргэлжлүүлэх, дэлхийн засаглал дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллах.” гэж, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2021 оны 02 дугаар зөвлөмжийн 2.1-д Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсаас цагдаагийн баг оролцуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д нийцүүлэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

#### **1.2.Практик үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Зэвсэгт хүчин нь анх 2002 онд Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс дахь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэргийн ажиглагчаар хоёр офицерыг илгээснээс хойш өнгөрсөн 21 жилийн хугацаанд дэлхийн 3 тивд явагдсан НҮБ-ын 15 энхийг сахиулах, эвслийн цэргийн 4 буюу нийт 19 ажиллагаанд 20000 гаруй цэргийн алба хаагч, 2016 оноос 2023 он хүртэл цагдаагийн байгууллагаас нийт 27 алба хаагч оролцож, дэлхий нийтийн энх тайван, аюулгүй байдлыг тогтворжуулахад хувь нэмрээ оруулж байна.

1960 онд Африкийн Ардчилсан Конго Улсад Энхийг сахиулах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, дотоодын үймээн самуунтай тэмцэх зорилгоор анх Гана Улсын 30 цагдааг оруулснаар НҮБ-ын цагдаагийн албаны үйл ажиллагаа эхэлсэн түүхтэй бөгөөд энэхүү цагдаагийн алба нь НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Ажлын албаны Энхийг сахиулах ажиллагааны газрын Хууль, эрх зүй, аюулгүй байдлын албаны бүтцийн нэгж юм.

Тухайн алба нь Цагдаагийн зөвлөх (Individual Police Officer), Цагдаагийн баг (Formed Police Unit), Цагдаагийн мэргэжилтнүүдийн баг (Specialized police team) гэсэн үндсэн гурван чиглэлээр НҮБ-ын ажилтнууд болон өмч хөрөнгө, энгийн иргэдийг хамгаалах, НҮБ-ын цагдаагийн албаны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүргүүдийг гүйцэтгэдэг.

НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаа, хоёр талын хамтарсан хээрийн сургууль, дадлагад оролцох Монгол Улсын оролцооны цар хүрээ, оролцогчдын тоо жилээс жилд өсөн нэмэгдсэнтэй холбогдуулан энхийг сахиулах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгон сайжруулах хэрэгцээ, шаардлага бий болсон.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн зохицуулалтаар зөвхөн Зэвсэгт хүчний цэргийн багт Монгол Улсын зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, цагдаа, тагнуул, онцгой байдлын болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бие бүрэлдэхүүнээс энхийг дэмжих ажиллагаанд оролцох, түүнд хамаарах сургалт, дадлага, хангалттай холбогдсон харилцааг зохицуулсан бөгөөд Монгол Улсын Цагдаагийн байгууллагаас энхийг дэмжих ажиллагаанд бие даан оролцуулах эрх зүйн зохицуулалт хязгаарлагдмал байна.

Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн 8.3.3-т “зэвсэгт хүчний үндсэн чиг үүргээ биелүүлэх, энхийг дэмжих ажиллагаанд оролцох, терроризмтой тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх” гэж заасны дагуу Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн сүүлийн 20 жилийн хугацаанд энхийг сахиулах ажиллагаанд оролцсон туршлага, хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулсан хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлт зэргийг үндэслэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн эрх зүйн зохицуулалтад зарчмын томоохон шинэчлэл хийх шаардлага бий болж байна.

Өөрөөр хэлбэл, хуулийн нэр томьёонд тусгасан зарим тодорхойлолт болон цэрэг, цагдаагийн багийн гүйцэтгэх үүргийг илүү нарийвчлан тодорхой болгож, энхийг дэмжих ажиллагаанд оролцогчийн нийтлэг үүрэг, энхийг дэмжих ажиллагааны удирдлагын тогтолцоог болон хуульд заасан Засгийн газар, холбогдох Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн зарим зохицуулалтуудыг боловсронгуй болгоно.

Түүнчлэн, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Монгол Улсын Засгийн газарт цэргийн багаа оролцуулсан үйл ажиллагааны зардалд олгосон нөхөн төлбөрөөс энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнд томилолтын зардал хэлбэрээр олгох, мөн Зэвсэгт хүчний хөгжлийн санд төвлөрүүлэх талаар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Дээрх хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлагыг үндэслэн хуулиар зохицуулагдаагүй орхигдсон харилцааг тодорхой болгох, хуульд “Цэрэг, цагдаагийн баг” гэсэн нэр томьёог шинээр тодорхойлох, Монгол Улсаас НҮБ-ын

болон олон улсын бусад ажиллагаанд оролцох төрлийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан тэдгээрийн гүйцэтгэх чиг үүрэг, энхийг дэмжих ажиллагааны удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, цэргийн багийн бие бүрэлдэхүүний нийтлэг үүрэг, ажиллагаанаас эгүүлэн татахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тусгах зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасны дагуу Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл нь нийт 4 бүлэг, 16 зүйлээс бүрдэх бөгөөд дараах харилцааг зохицуулахаар тусгасан.

“Энхийг дэмжих ажиллагааны сургалт, дадлага”, “Цэргийн баг, цагдаагийн баг” болон бусад нэр томьёоны тайлбар, энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүнд хамаарах НҮБ-ын албан тушаал, сонгон шалгаруулалтад тэнцсэн бие бүрэлдэхүүнийг томилох, эгүүлэн татах, цэрэг, цагдаагийн багийн гүйцэтгэх үүргийн төрөл, алба хаагчийн нийтлэг үүргийг тус тус тусгана.

Мөн энхийг дэмжих ажиллагаанд цагдаагийн багийн гүйцэтгэх үүргийн төрөл, цэрэг, цагдаагийн бие бүрэлдэхүүнийг энхийг дэмжих ажиллагааны албан тушаалд томилох, тэдгээрийн хүлээх нийтлэг үүрэг, ажиллагааны газар орноос эгүүлэн татагдсантай холбогдох зардлыг нөхөн төлүүлэх зэрэг зохицуулалтыг шинээр тусгана.

Түүнчлэн, энхийг дэмжих ажиллагааны удирдлага, зохион байгуулалт Засгийн газрын болон гадаад харилцаа, батлан хамгаалах, хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга болон цагдаагийн төв байгууллагын даргын бүрэн эрх, мөн цэрэг, цагдаагийн багийн захирагчийн нийтлэг эрх, үүрэг, энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүний эрх зүйн байдал, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэргийг тус тус тусгана.

### **Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараах нийгэм, эдийн засгийн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн шийдвэрээр энхийг сахиулах ажиллагаа болон олон улсын бусад ажиллагаанд оролцох цэрэг, цагдаагийн байгууллагын эрх зүйн зохицуулалт болон эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх, чиг үүргийг уялдаа холбоо тодорхой болж, Монгол Улсаас НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдэх, алба хаагчийн энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх чадавх дээшилнэ.

Түүнчлэн, Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд цэрэг, цагдаагийн багийг оролцуулснаар Монгол Улс НҮБ-ын гишүүн орны хувьд хүлээсэн үүргээ биелүүлэхэд ахиц гарах, мэргэжлийн ур чадвар дээшлэх, харилцан туршлага солилцох, гадаадад үүрэг гүйцэтгэж буй өөрийн орны цэргийн багтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх, ажиллагаанд ашиглаж буй зэвсэглэл, техникээс орж ирэх НҮБ-ын “нойтон” түрээсийн мөнгөн орлого улсын төсөвт орох зэрэг ач холбогдолтой болох юм.

**Дөрөв. Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай уялдуулах үүднээс шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал**

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд Цэргийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---oOo---